



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/204

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёл урлагийн үйлчилгээг орчин үеийн стандартад нийцүүлэн иргэдэд хүргэх зорилгоор Хөгжимт драмын театрын тайзны лед дэлгэц өндөрлөж суурилуулах зардалд 2,000,000 төгрөгийг зарцуулсугай.


2. Арга хэмжээнд зарцуулагдах 2,000,000 төгрөг (хоёр сая)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.4-д тусгагдсан “Олон үндэстэн ястны өв соёл урлаг” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын 19-ний өдрийн  
А/204 дүгээр захирамжийн  
хавсралт

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

Д/д	Материалын үнэ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Зарцуулагдах төсөв /мянган төгрөгөөр/
1	Квадрат төмөр 4x4	38	15000	570 000
2	Квадрат төмөр 4x6	36	18000	648 000
3	Угольник төмөр 5x5	26	15000	390 000
4	Араматор төмөр	12	12000	144 000
5	Бэхэлгээний боолт	24	4000	96 000
6	Ханын тэлэгчтэй шруп	12	3000	36 000
7	Электрод	2	25000	50 000
8	Таслагчны ир	50	800	40 000
9	Төмөр утас	2	13000	26 000
Нийт				2 000 000

-oOo-